Увдисын нэмсэн арга бүтээл дахь халдварт хижиг өвчний жор найрлагыг судалсан нь

Б.Алтанзул[1], Б.Цогт[2], Ч.Батнайрамдал[2]
[1,2]Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль, АШУҮИС
E-mail: altanzul_batsuren@yahoo.com Утас: 80322832

Түлхүүр үг
Увдисын нэмсэн арга, халдварт хижиг, эмийн жор

Товч утга
Монгол анагаах ухааны түүх эх зохиолын үндсэн чиглэл бол хүн зоноос өвчин эмгэгтэй тэмцэж ирсэн гол тулгуур, ойлголтууд хөгжлийн жам ёс үе шат эмч эрдэмтдийн зохиол бүтээлийг судлах асуудал юм. Үүний томоохон төлөөлөгч болох Ютиг Ёндонгомбо VIII зуунд Төвөд хэлээр бичигдсэн "Анагаах ухааны дөрвөн үндэс"-д халдварт хижгийг шалтгаан нөхцөл, мөн чанар, нэр, ялгал, шинж, засах арга зэрэг зургаан зүйлээр үзүүлж, халдварт хижиг (онгорил), бодо, гэдэсний хатгалга, сахуу боом, дагшуур (томуу) хижиг зэрэг таван зүйлээр тэмдэглэж, Дэсрид Санжаажамцын "Увдисын үндэсний нэмсэн арга"-д хижиг дөрвөн зүйл ба нян хижиг арван найм зүйл лугаа нэмсэнээр хорин хоёр буй гэж, хижиг халдварлах зам, эх сурвалж ба сэргийлэн засах зэргийг нарийн тайлбарлав. Халдварт өвчний ихэнх нь бие халуурах шинжтэй бөгөөд өвчлөл цочмог, тусах нь хүнд, өвчний хүч нэмэгдэх нь түргэн, явц богино, эндүүрэл ихтэй бөгөөд өргөнөөр халдварладаг. Иймээс тус бүтээлүүдийг гүнзгийрүүлэн судалж, эм найрлагыг тодруулан гаргах нь онол практикийн ач холбогдол ихтэй байгаа юм. Тус бүтээл нь ''Анагаах ухааны дөрвөн үндэс''-ийн ''Увдисын үндэс''-ийн 92 бүлгийг 133 бүлэг болгон дэлгэрүүлэн авч үзсэний дотор түүний эмчилгээний олон жилийн туршлага дээрээ тулгуурлан бичсэн нян хижиг өвчнийг анагаах талаар 22 бүлэг өвчин бичигдсэн бөгөөд тус бүтээлийн нийт өвчний 18%-ийг эзэлж байна. Тус бүтээлд нийт 549 жор байгаагаас, нэр өгч оноож нэрлэсэн жор 161, нэргүй эмийн түүхий эдүүдийг бичсэн жор 388 байна.

Үндэслэл
Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаа (ДЭМБ) албан баримт бичигтээ "нян, вирүс, шимэгч, мөөгөнцөр мэтийн эмгэг төрүүлэгч бичил биетээр өсч, хүнээс хүнд шууд болоод шууд бусаар тардаг өвчнийг халдварт өвчин гэнэ[6]. Дэлхийн хэмжээнд 2019 оны 7 сарын байдлаар 57 төрлийн халдварт өвчин бүртгэгдэж 108 улс бүс нутгийг хамарсанаас Томуу, Томуу төст өвчин, Улаан бурхан (56), Денге чичрэг өвчин (32), Чикунгунья өвчин (16), Холер (11), Хумхаа (7) бүртгэгдсэнээс эхний 3 нь нас баралтаар Эболагийн цусархаг тууралтаас 67.2%, Ойрхи Дорнодын амьсгалын замын хам шинжээс 34.5%, Ласса халууралтаас 22.5%-иар их тархац аюул бүхий өвчнүүд юм[9].
Монгол улсын хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 31 төрлийн 33376 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 101.2 ногдож байна. Өмнөх оны үеэс 11 856 тохиолдлоор буюу 10 000 хүн амд ногдох өвчлөл 38.5-аар буурсан байна. Мөн өнгөрсөн оны үетэй харьцуулахад мөөгөнцөр (1475), хачигт рикеттсиоз (43), нярайн бактерт үжил (1), ХДХВ/ДОХ (7), тарваган тахал (4), С хепатит (4), хумхаа (1), балнад (1), татран (1), галзуу (1) хачигт энцеофалит (1) тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна[10].

Дэлхийн хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, байгаль экологийн өөрчлөлт хувьсал зэрэг нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдэхэд төвөгтэй байдал бий болгож байна. Байгаль экологи, уур амьсгал, агаар мандал, хүний амьдрах орчны нөхцөлүүд өөрчлөгдөн хувьсаж, хүний эрүүл мэндэд нөлөөлөх олон хүчин зүйлсэд чанарын болон тооны эрс өөрчлөлтүүд гарч вирус, нянгууд ч хувьсаж,

урьд хойчид огт байгаагүй өвчнүүд, тэдгээрийн шинэ эх үүсвэрүүд бий болж дамжин халдварлах эрсдэл улс орнуудад хил хязгаар, цаг хугацааг харгалзахгүйгээр үүсэж байгаа бөгөөд вируст халдварууд гарч, улс орнууд эрүүл мэндийн болон эдийн засгийн их хохирол учруулж байгаа тул халдварт өвчнийг улам сайтар судлах шаардлага тулгарч байна[4,5,6].

Монгол анагаах ухааны түүх эх зохиолын үндсэн чиглэл бол хүн зоноос өвчин эмгэгтэй тэмцэж ирсэн гол тулгуур, ойлголтууд хөгжлийн жам ёс үе шат эмч эрдэмтдийн зохиол бүтээлийг судлах асуудал юм. Үүний томоохон төлөөлөгч болох Ютиг Ёндонгомбо VIII зуунд Төвөд хэлээр бичигдсэн "Анагаах ухааны дөрвөн үндэс"-д халдварт хижгийг шалтгаан нөхцөл, мөн чанар, нэр, ялгал, шинж, засах арга зэрэг зургаан зүйлээр үзүүлж, халдварт хижиг (онгорил), бодо, гэдэсний хатгалга, сахуу боом, дагшуур (томуу) хижиг зэрэг таван зүйлээр тэмдэглэж, "Увдисын үндэсний нэмсэн арга"-д хижиг дөрвөн зүйл ба нян хижиг арван найм лугаа нэмэгдсэн хамтарснаар хорин хоёр буй гэж, хижиг халдварлах зам, эх сурвалж ба сэргийлэн засах зэргийг нарийн тайлбарлав. Халдварт өвчний ихэнх нь бие халуурах шинжтэй бөгөөд өвчлөл цочмог, тусах нь хүнд, өвчний хүч нэмэгдэх нь түргэн, явц богино, эндүүрэл ихтэй бөгөөд өргөнөөр халдварладаг. Иймээс тус бүтээлүүдийг гүнзгийрүүлэн судалж , эм найрлагыг тодруулан гаргах нь онол практикийн ач холбогдол ихтэй байгаа юм[2].

Судалгааны ажлын зорилго

Увдисын нэмсэн арга бүтээлээс халдварт хижиг өвчний жор найрлагыг тодруулах, сурвалж зохиолтой харьцуулан судлах

Судалгааны ажлын зорилт

1. Дэсрид Санжаажамц ''Увдисын нэмсэн арга'' бүтээлийн халдварт хижиг өвчний жор найрлагыг тодруулах
2. Уг зохиолын халдварт хижиг өвчний жор найрлагыг ''Анагаах ухааны дөрвөн үндэс'' сурвалж зохиолтой харьцуулах

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн, арга зүй

Дэсрид Санжаажамцын ''Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын эрдмийн үндэсийн нэмсэн арга, эмгэгийг энэлгэхүй халууныг арилгагч гавар, цаг бусын үхлийн цэлмийг огтлогч илдэн'' буюу ''Увдисын нэмсэн арга'' хэмээн Төвөд хэлээр бичигдсэн 1991 онд Хөх нуурын хэвлэлийн хороонд хэвлэсэн, дэвтэр ном 667 хуудастай бүтээлийг эх хэрэглэгдэхүүн болгож эх бичиг, сурвалж бичиг судлалын аргыг ашиглан эрт дээр үеэс тэмдэглэж үлдээсэн баримт бичгээс тодруулан судалж, харьцуулалтын аргаар бусад эх зохиолтой харьцуулан, шүүн тунгаан үзэхэд энэхүү аргыг хэрэглэсэн.

Судалгааны ажлын үр дүн

Тус бүтээл нь ''Анагаах ухааны дөрвөн үндэс''-ийн ''Увдисын үндэс''-ийн 92 бүлгийг 133 бүлэг болгон дэлгэрүүлэн авч үзсэний дотор түүний эмчилгээний олон жилийн туршлага дээрээ тулгуурлан бичсэн нян хижиг өвчнийг анагаах талаар 22 бүлэг өвчин бичигдсэн бөгөөд тус бүтээлийн нийт өвчний 18%-ийг эзэлж байна. Тус бүтээлд нийт 549 жор байгаагаас, нэр өгч оноож нэрлэсэн жор 161, нэргүй эмийн түүхий эдүүдийг бичсэн жор 388 байна. АУДҮ-т амирлуулах эмийг тан эм, талх эм, үрэл эм, зуурмал эм, тосон эм, үнсэн эм, ханд эм, архин эм, эрдэнийн эмийн найрлага, өвсөн эмийн нарийлага гэж арван зүйлд ангилсан байна. Тан эм, талхан эмэнд нэр оноож нэрлэсэн болон нэргүй найрлагууд гарсан бөгөөд нэр оноож нэрлэсэн талхан эм нь АУДҮ-т 16 байснаас Увдисын нэмсэн аргад 38 төрөл зүйл болж нэмэгдсэн байна. Үрэл эм нь АУДҮ-т хамгийн анх 3- н төрөл зүйл тэмдэглэгдэж байсан бол ''Увдисын нэмсэн арга''-д 6 зүйл болсон байгаа нь эм найрлагыг улам баяжуулан нарийн тэмдэглэгдэж, нэрлэж ирсэн нь харагдаж байна. Халдварт хижиг өвчний тангийн жор найрлагын хувьд АУДҮ-т Мана-4, гурван шимтийн тан, бибилингийн тан, арүрийн тан, лидэрийн тан, лидэр-4, жамц-4, батла-5, дэгд хэсрийн тан, хатгалга-3 гэх нийт 10 тан бичигдсэн бол ''Увдисын нэмсэн арга''-д мана-4, лидэрийн тан, дэгдийн тан, шар тан дурдсан байна. Бодо өвний үед АУДҮ-т мана-4, лидэрийн тан, дэгдийн тан, шар тан бичигдсэн бол ''Увдисын нэмсэн арга''-д морин шарилжны тан, гахайн баасны танг нэрлэсэн байна. Гэдэсний хатгалга өвчний үед АУДҮ-т сэржид-7, бонгарын танг, ''Увдисын нэмсэн арга''-д индрагийн танг тус тус нэрлэсэн байна. Боом, сахуу, томуу өвчний үед АУДҮ-т танг дурьдаагүй бөгөөд харин ''Увдисын нэмсэн арга''-д гүгүлийн тан, морин шарилжны танг тэмдэглэсэн байна. Олонх халуун халдварт өвчнүүдэд хамгийн эхэнд хөлрүүлэх тан өгч дараа нь нянгийг нядлах жоруудыг хэрэглэдэг. Үүнд: Мана-4, шар тан, лидэрийн тангуудыг олонх хэрэглэсэн байна.

АУДҮ-т байх халдварт өвчнүүдэд хэрэглэгдэх нэртэй талх эмний олонхид нь гарьд, гавар, баатар зэргийн найралтууд илүү тэмдэглэгдсэн байна.

Халдварт хижиг өвчний үед АУДҮ-т гавар-3, гавар-5, гавар-7, гавар-25, эрхэм-8, жахүр-5, түшмэл-3 зэрэг 7 төрлийн нэртэй талх эмийг тэмдэглэсэн ба голдуу халуун өвчнийг анагаах Гаврын найрлагыг илүү тэмдэглэсэн байна.
''Увдисын нэмсэн арга''-д банзи-12, анагаагч-9, бурнаг-29, бүрнаг-32, дэва-5, дэва-10, агар-35, агар-8, амь баригч-9, саран болор ногоон найрлага зэрэг 10 төрлийн нэртэй талхан эмийг тэмдэглэсэн бөгөөд ихэвчлэн нянг нядлах бүрнаг, дэвагийн найрлага, хийг дарах найрлагыг илүү тэмдэглэсэн нь ''Анагаах Ухааны Дөрвөн үндэс'' дахь эм найрлагаас ялгаатай байна.

Сурвалж тайлбарын баримтаас авч үзвэл 8-р зууны сүүлээр бичигдсэн "Анагаах ухааны дөрвөн үндэс"-т хамгийн анх тодорхой нэртэй талхан эм 16 бичигдсэн бөгөөд бичигдсэн цаг хугацааны дарааллаар Дэсрид Санжаажамцын 1691 онд бичсэн "Увдисын нэмсэн арга"-д 38 найрлага болон нэмэгдсээр ирсэн байна. Мөн нэмэлт хачир анх АУДҮ-т 45 төрөл зүйл байсан бол "Увдисын нэмсэн арга"-д 54 төрөл зүйл болж нэмэгдсэн байна.

Хэлцэмж

Уламжлалт анагаах ухааны эртний сурвалж "Найман гишүүнт"-д халдварт халуун өвчний шалтгааныг "Хамрын баруун зүүн нүхний рома, жонма гэх хоёр судалтай холбож тэрхүү судал өвчин үүсгэх тодорхой нөхцөлүүдээс болж дарагдснаас болж үүсдэг. Өвчний гол орныг хамар, хоолой, уушги гэж ялгасан"[3] байдаг. Түүнчлэн "Анагаах ухааны дөрвөн үндэс "-т халдварт халуун өвчнийг "Цусны оронд орших зэс мэт нарийн болоод үл үзэгдэх хорт хорхойгоос үүсэх" ба "үүсгэгч нь орон, цаг, идээ явдлын нөхцөлөөр хямарч биеийн тамирыг идээд өвчин болюу"[1] гэсэн бол "Манаг лхантав"-д тус өвчнийг нэг зүйлийн "гүрвэл мэт толгойтой хомхой хорхой гэгээн завсрын орноос шар усны нүх, хамрын үүдээр орж, биеийн дотор улаан өнгөтэй, хөлгүй бөөрөнхий бөгөөд, жижиг нарийн, хүний нүдэнд үзэгдэхгүй, нэгэн агшинд бүх биед судлын дотор гүйж чаддаг цусны хорхойтой хамт оршиж, хамаг өвчний шалтгаан болдог"[2] гэх мэтээр сурвалж, зарим тайлбаруудад халдварт хижиг өвчний шалтгаан нөхцөл, өвчний орох үүд, өвчний ангилал, биед тархах талаар тодорхой бичиж ирсэн байна.
Орчин үеийн эмнэлгийн шинжлэх ухаанд элдэв өвчнөөс урьдчилан сэргийлэх олон төрлийн вакцин олж нээхэд монголчуудаас жинтэй хувь нэмэр оруулсан гэж үзэх бүрэн үндэслэл бий гэж Академич Ц.Хайдав үзсэнтэй нэг утгатай байгаа юм.

Түүнчлэн энэ агуулгын хүрээнд Цахар гэвш Лувсанчүлтэмийн монгол анагаах ухаанд оруулсан зарим нэг хувь нэмрийг тодруулах зорилгоор академич П. Нямдаваа, Ш.Болд нар судалгааны өгүүлэл хэвлүүлсэн байдаг.
Мөн судлаач Эрдэнэгуа нарын судалгааны баг халдварт өвчний эмнэл зүйн жорын талаар харьцуулан судласан байгаа нь бидний судалгаатай дүйж байна.

Өгүүлэлд "Монгол оточ Лувсанцүлтэм бодогоос сэргийлэх ерөндөг боловсруулах аргыг бичиглэсэн "Тэнгэрийн цагаан цэцэг тарих, эм найруулах ёсон хийгээд татах тэргүүтний бичиг" хэмээх бүтээлээ Э.Женнерээс 13 жилийн өмнө буюу 1785 онд нийтлүүлжээ.

Дүгнэлт

Халдварт өвчний эх сурвалжууд дахь халдварт өвчнүүдийг анагаах эмийн харьцуулахад АУДҮ-т нийт 182 найрлага тэмдэглэгдсэн бол ''Увдисын нэмсэн арга''-д 192 найрлага тэмдэглэгджээ. Мөн хачир эмийг анх АУДҮ-т 45-н зүйл, "Увдисын нэмсэн арга"-д 54 зүйл болж нэмэгдсэн байна. Үрэл эм анх АУДҮ-т 3, "Увдисын нэмсэн арга"-д найрлага тэмдэглэгджээ. Энэ нь он цагийн дарааллаар өвчин нэмэгдэхийн хирээр эмийн найрлагын төрөл зүйл болон тоо хэмжээ нь улам баяжигдан нэмэгдсэн болохыг харуулж байна.

Ном зүй

1. *Ютиг Ёндонгомбо. Анагаах ухааны дөрвөн үндэс. Төвөдийн Хөхнуурт. 1992 он. х276*
2. *Дэсрид Санжаажамц. "Манаг лхантав" Эмхэтгэж хэвлүүлсэн Төмөр. Өвөр Монголын үндэстний хэвлэлийн хороо. 2016 он.х.152-267*
3. *Ловонбаво. Найман гишүүнтийн зүрхний хураасан судар оршив.Эмхэтгэсэн Ма Мин. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2016. х317-334*
4. *Халдварт өвчин судлалын монголын сэтгүүл.№5(94) 2020.УБ. х.3*
5. *Халдварт өвчин судлалын монголын сэтгүүл.№6(95) 2021.УБ. х.8*
6. *Ш.Болд. "Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийн эх сурвалжийн судалгаагаар тодруулах*

нь". Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол. УБ хот. 2005 он.
7. Ред. Н.Хоролсүрэн. Я.Дагвадорж. Халдварт өвчин.УБ хот. 2010 он. х.3-4.
8. Bi Q, Wu Y, Mei S, et al. Epidemiology and transmission of COVID-19 in 391 cases and 1286 of their close contacts in Shenzhen, China: a retrospective cohort study. The Lancet Infectious Diseases. 2020.
9. Хан Хуй, У Бө. 2019 оны 7 сарын байдлаарх Дэлхий даяарх халдварт өвчний тархалт. Disease surveillance. August 30, 2019, Vol.34, No.8 х.689
10. ХӨСҮТ-ийн тандалтын алба, Үндэсний статистийкийн хороо. 2021 он.

Study of recipe and ingredients for healing contagious hot disorders from "the added method of oral instruction tantra" written by Desrid Sanjaajamts

Altanzul B[1], Tsogt B[2] , Batnairamdal Ch[2]
[1,2]International School of Mongolian Traditional Medicine. MNUMS
E-mail: altanzul_batsuren@yahoo.com

ABSTRACT

One of the main representative of these studies was Yutig Yondongombo who wrote in VIII century in Tibetan language the book "Four Tantras" in which he described in 6 classifications contagious hot disorder's cause and condition, essence, name, difference, symptoms and healing/curing method. Also described 5 contagious hot disorder types: balnae, intestinal pain, small pox, diphtheria and inflammation of muscle tissues, and the common cold. In Desrid Sanjaajamts's book "The Added Method of Oral Instruction Tantra" he thoroughly explained 4 types of contagious hot disorders and 18 bacteria hot disorders which he combined and summed 22 hot disorders in total. He clarified the ways and source of infections and methods for healing recipe and its ingredients. Most contagious diseases common symptoms are fever and illness is acute and severe, progresses to worse condition very quickly, process is short, have many cases of misdiagnosis and widely infected.

Therefore, we have chosen this topic because there is crucial need to study thoroughly those books and clarify the recipes and their ingredients which have both theoretical and practical significance. We used methodologies such as 1.Hermeneutic method, 2.Histroical comparative method, 3. Analysis and Synthesis method, and 4.Original text studies and source study for the research.

The book contains total of 133 diseases including based on his years of treatment experience and 22 diseases were added regarding to contagious hot disorders, which hold 18% of total diseases in the book. The book has total of 549 recipes including 161 named recipes, and 388 anonymous herbal recipes.

Key Words: The Added Method of Oral Instruction Tantra, Contagious Hot Disorders, recipe and ingredients